

## ТАНИЛЦУУЛГА

### Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар

Монгол Улсын Их Хурлаас 2017 баталсан Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга нь 17 бүлэг, 255 зүйл, 1058 хэсэг, 908 заалттай бөгөөд тус хуулийн тусгай ангид нийт 2300 орчим үйлдлийг зөрчилд тооцож, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах зохицуулалттай байна.


Зөрчлийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд буюу 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 05 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас 7.334.349 зөрчилд шийтгэл оногдуулсан байна.

	Нийт шийтгүүлсэн	Шийтгэл оногдуулсан хэлбэр			
		Газар дээр нь хялбаршуулсан /Цагдаа/	Бүртгэлд авч хялбаршуулсан	Зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэгт шийтгэл оногдуулсан	Шүүхээс шийтгэл оногдуулсан
2017 оны сүүлийн хагас	<b>595,541</b>	584,043	9,283	2,173	42
2018 он	<b>1,679,929</b>	1,589,920	76,526	7,141	6,342
2019 он	<b>2,229,122</b>	2,111,570	94,888	6,466	16,198
2020 он	<b>2,233,967</b>	2,107,816	100,544	5,394	20,213
2021 оны эхний 5 сар	<b>595,790</b>	543,529	41,856	1,852	8,553
нийт	<b>7,334,349</b>	6,936,878	323,097	23,026	51,348


Үүнээс 96.7 хувийг хүнд, 3.3 хувийг хуулийн этгээдэд оногдуулсан байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зааснаар 31 байгууллагын 216 орчим нэгжид хамаарах 10011 субъект зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж байгаа бөгөөд Зөрчлийн тухай хууль хэрэгжих хугацаанд тухайн жилд бүртгэгдсэн нийт зөрчлийн 95 дээш хувийг цагдаагийн байгууллага харьяалан шалган шийдвэрлэсэн үзүүлэлттэй байна.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны эхний 05 сарын байдлаар нийт 7.306.386 зөрчил бүртгэгдсэнийг хугацаагаар нь авч үзвэл 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 592.742, 2018 онд 1.698.178, 2019 онд 2.175.825, 2020 онд 2.276.868, 2021 оны эхний 05 сарын байдлаар 562.773 зөрчил бүртгэгдсэн байна.



Ийнхүү цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн зөрчлийг Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалтаар нь үзвэл 6.696.529 буюу 93.0 хувь нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих /14.7/, 257.071 буюу 3.5 хувь нь Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах /5.1/, 18.238 буюу 0.2 хувь нь Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих /10.4/, 30.406 буюу 0.4 хувь нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих /5.4/, 14.715 буюу 4.4 хувь нь Танхайрах /5.2/, 2.681 буюу 0.03 хувь нь Тамхины хяналтын тухай хууль зөрчих /6.3/, 280.907 буюу 3.8 хувь нь бусад төрлийн зөрчил эзэлж байна.



Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 2021 оны эхний 05 сарын байдлаар цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд нь бэлэн бус хэлбэрээр нийт 6.154.933 удаагийн 168 тэрбум 648 сая төгрөгийн торгох шийтгэл оногдуулснаас 3.035.324 удаагийн 73 тэрбум 339 сая төгрөгийн торгох шийтгэл төлөгдөөгүй байсан.

Ийнхүү цагдаагийн байгууллагын шалган шийдвэрлэж байгаа зөрчлийн дийлэнх хувийг эзэлж байгаа Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлд заасан замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай зөрчих зөрчлийн шийтгэлийг оновчтой тогтоох, бусад оронд хэрэгжиж байгаа эрх зүйн оновчтой зохицуулалтыг судалж хэрэгжүүлэх, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хувилбараар авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн мэдээллээр хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулсан гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт сүүлийн 3 жилийн дунджаар 81 хувь байгаа боловч, мөнгөн дүнгийн биелэлт 45 хувь байна. Торгох шийтгэлийн үр нөлөө, биелэлт хангалтгүй, шийтгэлийн шинэ арга механизм, оновчтой хувилбарыг бий болгох зайлшгүй шаардлага байгааг дээрх тоон үзүүлэлт харуулж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдөр Тулгар төр байгуулагдсаны 2230 жил, Их Монгол Улсын 815 жил, Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан хүмүүнлэг, энэрэнгүй ёсны зарчмыг удирдлага болгон коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор зарим гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлага, зөрчлийн шийтгэлээс нэг удаа өршөөн хэлтрүүлэх, чөлөөлөх, хасах, ялын төрлийг солих зохицуулалт бүхий Өршөөл үзүүлэх тухай хуулийг баталсан. Тус хуулиар Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар

зүйл буюу Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил үйлдсэн хүн 2021 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор торгох шийтгэлийн төлбөрийн 50 хувийг төлсөн бол үлдсэн хувийг өршөөн чөлөөлөхөөр заасан.

Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн судалгаагаар Өршөөл үзүүлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт хамаарах 2.804.816 зөрчлийн 33.258.550.000 төгрөгийн мөнгөн дүн бүхий торгох шийтгэлийн төлбөр байсан болно.

Хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд буюу 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийслэлд 820.371 зөрчлийн 8.349.022.500 төгрөгийн мөнгөн дүн бүхий торгох шийтгэлийн төлбөр төлөгдсөн буюу 47.0 хувь, орон нутагт 381.581 зөрчлийн 5.463.485.000 төгрөгийн мөнгөн дүн бүхий торгох шийтгэлийн төлбөр төлөгдсөн буюу 35.2 хувийн биелэлттэй байна. Ийнхүү улсын хэмжээнд нийт 1.201.952 зөрчлийн 13.812.507.500 төгрөгийн мөнгөн дүн бүхий торгох шийтгэл төлөгдсөн буюу 41.5 хувийн биелэлттэй байна.

Дээрх тоо баримтаас харахад Зөрчлийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд тус хуулийн 14.7 дугаар зүйл буюу Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил үйлдсэн хүнд оногдуулсан нийт 66.517.100 төгрөгийн мөнгөн дүн бүхий торгох шийтгэлийн биелэлт бодит байдал дээр 13.812.507.500 төгрөг төлөгдсөн буюу 20.7 хувь биелэгдсэн байна гэж үзэхээр байна.

Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, Зөрчлийн тухай хуулийн төслийн хуулийн төслийн үзэл баримтлал, хууль зүйн болон практик шаардлагад үндэслэн Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийг боловсруулахдаа Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 1-1/427 дугаар албан бичгийн дагуу Зөрчлийн тухай хуулийг хэрэглэх болон хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа асуудал болон Зөрчлийн тухай хуулийн талаар тодорхой санал, дүгнэлт ирүүлснийг судалж, холбогдох зохицуулалтуудад тусгасан болно.

Түүнчлэн 2020 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулж шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнууд болох Авлигатай тэмцэх газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Оюуны өмчийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Архивын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын газар, Иргэний нисэхийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, иргэдийн төлөөлөл нийт 149 оролцогчдын санал, шүүмжлэлийг харгалзан үзлээ.

Харин тус хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь хуулийн төслийг 16 бүлэгтэй 267 зүйл, 1182 хэсэг, 429 заалттай байхаар боловсрууллаа. Энэ нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн зүйл, хэсэг, заалтын тоотой ойролцоо байна. Харин энэ нь хүчин төгөлдөр хуульд хуулиар хориглосон, журамд заасныг зөрчсөн, үүргээ биелүүлээгүй зэрэг хэт ерөнхий байдлаар нэг хэсэг, заалтад багтаан тусгасан боловч энэ нь салбарын хууль, захиргааны хэм хэмжээний актад заасан

үйлдлүүд нь хэдэн ч зөрчил болж өсөх боломжтой байгаа тул хүрээ хязгаарыг нягталж, зөрчлийн үйлдлийг хуулийн төсөлд тодорхой хэд хэдэн үйлдэл болгон тусгасан.

### **Ерөнхий ангийн хувьд**

Нэгдүгээр бүлэг буюу нийтлэг үндэслэл хэсэгт хуулийн зорилго, зарчим, хууль үйлчлэх нутаг дэвсгэр, хугацаа, хөөн хэлэлцэх хугацааны талаар тусгалаа.

Хууль ёсны зарчмын хүрээнд энэ хуулийн нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримтлах, энэ хуулийн нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад захиргааны хэм хэмжээний актыг ашиглаж болох зохицуулалтыг нэмж тусгалаа.

Хөөн хэлэлцэх хугацааны талаарх зохицуулалтад Нийгмийн даатгалын болон Татварын тухай хууль зөрчих, Өрсөлдөөний тухай хууль зөрчих үйлдлийн хөөн хэлэлцэх хугацааг тусгайлан заасан болно. Тухайлбал, өрсөлдөөний зөрчил нь нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг үр дагавараараа бусад захиргааны зөрчилтэй харьцуулахад үлэмж их бөгөөд зарим зөрчил нь нууц далд байдлаар явагддаг бөгөөд илрүүлж тогтооход маш хүндрэлтэй, тооцоо судалгаа их хийгддэг, цаг хугацаа их шаарддаг байдлыг харгалзан тусгалаа.

Мөн Зөрчлийн тухай хуульд торгох шийтгэлийг хөрөнгө, орлого, нөхөн төлбөр, хохирлын тодорхой хувиар тооцон оногдуулахаар заасан зөрчил үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн, баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэнээс хойш зургаан сар өнгөрсөн бол шийтгэл оногдуулахгүй байх зохицуулалтыг тусгаад байна.

Хүчин төгөлдөр Зөрчлийн тухай хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн бол хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй гэж заасныг өөрчилж хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж, харин шийтгэл оногдуулахгүй байхаар тусгалаа. Учир нь аливаа зөрчилд хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахгүйгээр хөөн хэлэлцэх хугацаа дууссан эсэхийг тогтоох боломжгүй юм.

Хоёрдугаар бүлэгт зөрчил, зөрчил хамтран үйлдэх, зөрчил үйлдсэн хугацаа, газрын талаарх зохицуулалтыг тусгалаа. Энэ бүлэг хүчин төгөлдөр үйлчилж байгаа зөрчил үйлдсэн зохицуулалтыг хэвээр хадгалсан.

Гуравдугаар бүлэгт шийтгэл оногдуулах үндэслэл, шийтгэл хүлээх хүн, хуулийн этгээд, шийтгэлийн төрөл, шийтгэл оногдуулахгүй байх үндэслэл, шийтгэлийг хөнгөрүүлэх үндэслэл, зөрчлийн улмаас бий болсон хор уршгийг арилгах, тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигчид шийтгэл оногдуулах зохицуулалтыг тусгалаа.

Энэ бүлэгт шийтгэлийн төрлийг нэмэгдүүлж сануулах шийтгэлийг шинээр бий болголоо. Өөрөөр хэлбэл, хуулийн тусгай ангид заасан зөрчлийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд тухайн зөрчлийн үр дагаварыг тайлбарлаж, зөрчлийг арилгах боломж олгохыг сануулахаар тусгалаа. Харин энэ шийтгэлийн төрлийг тусгай ангид сонгож оногдуулахаар заасан зөрчилд бусад шийтгэлийг оногдуулахгүйгээр заавал эхэлж оногдуулахаар тусгасан болно. Сануулах шийтгэлийг оногдуулснаас хойш 6

сар өнгөрөөгүй бол дараагийн үйлдсэн зөрчилд сануулах шийтгэлийг оногдуулахгүй байхаар боловсрууллаа.

Энэ нь тухайн үйлдэгдсэн зөрчлийн нийгмийн хор аюулын хэмжээ, шууд хор хохирол учраагүй, зөрчлийг арилгах боломжтой үйлдлүүдэд хүн, хуулийн этгээдэд сануулах замаар нийгмийн дэг журмыг хангах, нөгөө талаар хүн, хуулийн этгээдэд шууд торгох шийтгэл оногдуулахаас илүүтэйгээр сануулах, зөвлөх, тайлбарлах боломжийг олгох ач холбогдолтой юм.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрх бүхий этгээд нь энэ хуулийн тусгай ангид дээд, доод хязгаартай байхаар заасан торгох шийтгэлийг оногдуулахдаа зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн зөрчлийн үр дагавар, учруулсан хохирлыг арилгасан, нөхөн төлбөрийг төлсөн байдлыг харгалзахаар тусгасан. Өөрөөр хэлбэл тусгай ангид заасан зарим зөрчилд оногдуулах торгох шийтгэлийн хэмжээг интервалтай байх зохицуулалтыг шинээр бий болголоо.

Түүнчлэн зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг тогтоосон хугацаанд биелүүлсэн бол шийтгэлийг 2 дахин хөнгөрүүлдэг байх зохицуулалтыг шинээр тусгалаа. Энэ нь торгох шийтгэлээр шийтгэгдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэлийг цаг хугацаандаа биелүүлэх хөшүүрэг, нөгөө талаас хуулийн хэрэгжилт, хуулиар оногдуулсан шийтгэлийн биелэлт бүрэн хангагддаг байх боломж бүрдэнэ үзэж байна.

Энэ нь Зөрчлийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд тус хуулийн тусгай ангид заасан зөрчлийн үйлдэлд оногдуулсан торгох шийтгэлийн биелэлт бодит байдал дээр 20.7 хувь байгаа дээр дурдсан нөхцөл байдалд дүн, шинжилгээ хийсний үндсэн дээр боловсруулсан зохицуулалт болно.

Ийнхүү шийтгэлийг хөнгөрүүлэх үндэслэл нь зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд албадлагын арга хэмжээнээс чөлөөлөх үндэслэл болохгүй байхаар боловсрууллаа. Харин нийтийн эрх ашгийг хамгаалах, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, ФАТФ-ийн зөвлөмжийг хэрэгжүүлэх шаардлагаар Зөрчлийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтад заасан зөрчлийн шийтгэлийг хөнгөрүүлэх зохицуулалтад мөн хамааруулахгүй байхаар тусгав. Тухайлбал, байгаль орчин, хүрээлэн байгаа орчны эсрэг бүлэгт заасан зөрчил бүхэлдээ, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, мөрийтэй тоглох, Галт зэвсгийн тухай хууль зөрчих, жагсаал цуглаан зохион байгуулах журам зөрчих, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль зөрчих, Донорын тухай хууль зөрчих, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль зөрчих, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих, зэрэг нийт 61 зүйл бүхэлдээ, 5 зүйлд хамаарах 25 хэсэгт заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн шийтгэлээс чөлөөлөх, хөнгөрүүлэх боломжгүй байхаар тусгалаа.

Прокурорын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалад “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно.” гэж, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно.” гэж тус тус заасан.

Иймд хуулийн дээрх зохицуулалтай уялдуулан Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол Прокурорын тухай хуулийн<sup>1</sup> 20 дугаар зүйлд заасны дагуу прокурорын байгууллага төрийн эрх бүхий байгууллагын хүсэлтээр шүүхэд хандаж, шийдвэрлүүлэх зохицуулалтыг шинээр тусгалаа.

Түүнчлэн баривчлах шийтгэлийг оногдуулахгүй байх этгээдийн хүрээ хязгаарыг иргэдийн зүй ёсны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн харьцангуй өргөжүүлэн тусгалаа. Ийнхүү шүүх баривчлах шийтгэлийг энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд оногдуулах ба жирэмсэн эмэгтэй, 0-3 насны хүүхэдтэй эх, арван зургаа хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх, хөдөлмөрийн чадвараа 70, түүнээс дээш хувь алдсан хүн, хүнд өвчтэй хүнийг асран хамгаалж байгаа хүн, баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүн, бусад хүндэтгэн үзэх шалтгаантай хүнд оногдуулахгүй байхаар тусгалаа. Энэ хэсэгт заасан “хүндэтгэн үзэх бусад шалтгаан”-ыг шүүхээс тогтоон хэрэгжүүлэх замаар шийдвэрлэх боломжтой болсон.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу 24 цаг, түүнээс дээш хугацаагаар саатуулагдсан хүнд торгох шийтгэл оногдуулах бол нэг саатуулагдсан нэг хоногийг арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тооцож торгох шийтгэлээс хасаж тооцож байсныг хорин нэгж болгон өөрчилсөн. Энэ нь зөрчил үйлдсэн хүн нь эрх бүхий этгээдээс оногдуулсан шийтгэлийг богино хугацаанд барагдуулах боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой.

Дөрөвдүгээр бүлэгт албадлагын арга хэмжээний талаар буюу хөрөнгө, орлогыг хураах, шилжүүлэх, зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах, хохирол, нөхөн төлбөр гаргуулах, албадан эмчлэх болон албан сургалтын талаар тусгалаа. Албадан сургалтыг баривчлах шийтгэлийг эдэлж байх хугацаанд хэрэгжүүлэхээр агуулгаар үйлчилж байсныг өөрчилж баривчлах шийтгэлийг эдлэх хугацаанаас гадна энэ хуулийн 3.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан үндэслэлээр баривчлах шийтгэл оногдуулаагүй, эсхүл торгох шийтгэл шийтгэгдсэн, эсхүл шийтгэлээс чөлөөлөгдсөн хүнийг албадан сургалтад хамруулах зохицуулалт тусгалаа.

### **Тусгай ангийн хувьд**

Тус хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд буюу 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 05 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд прокурорын байгууллагад хамгийн олон бүртгэгдсэн зөрчлүүдийг зүйлээр авч үзвэл:<sup>2</sup>

Д/д	Зүйлийн гарчиг	Нийт бүртгэгдсэн
1	14.7 дугаар зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих	6,640,580
2	5.1 дүгээр зүйл.Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах	259,626
3	14.6 дугаар зүйл.Автотээврийн тухай хууль зөрчих	65,576

<sup>1</sup> Төрийн мэдээлэл эмхтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Улсын ерөнхий прокурорын газраас ХЗДХЯ-д ирүүлсэн тоон баримт дээр үндэслэн боловсруулсан тоо болно.

4	5.3 дугаар зүйл.Хүний биед халдах	41,495
5	11.15 дугаар зүйл.Жолоочийн даатгалын тухай хууль зөрчих	36,813
6	15.24 дүгээр зүйл.Иргэний улсын бүртгэлийн тухай хууль зөрчих	36,167
7	5.4 дүгээр зүйл.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих	30,603
8	15.9 дүгээр зүйл.Хуурамч дуудлага, мэдээлэл өгөх	24,283
9	5.5 дугаар зүйл.Нийтийн зориулалттай орон сууцны оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах	18,694
10	5.2 дугаар зүйл.Танхайрах	18,506
11	14.5 дугаар зүйл.Авто зам, замын байгууламж, тэмдэг, тэмдэглэлийг гэмтээх, өөрчлөх, бохирдуулах	16,482
12	10.4 дүгээр зүйл.Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих	15,536
13	8.6 дугаар зүйл. Хулгайлах	11,231
14	6.3 дугаар зүйл.Тамхины хяналтын тухай хууль зөрчих	10,188
15	11.19 дүгээр зүйл.Татварын хууль зөрчих	9,552
16	15.2 дугаар зүйл.Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах	7,062
17	8.8 дугаар зүйл.Эд хөрөнгө устгах, гэмтээх	6,757
18	6.20 дугаар зүйл.Хүүхдийн эрхийг зөрчих	6,638
19	6.5 дугаар зүйл.Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих	6,510
20	5.13 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих	3,709
21	16.2 дугаар зүйл.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль зөрчих	2,072

Дээрх тоон үзүүлэлтээс харахад Дээд боловсролын тухай хууль зөрчих, Дархлаажуулалтын тухай хууль зөрчих, Шуудангийн тухай хууль зөрчих, Гэмт хэргийг нуун далдах, Мал амьтны эрүүл мэндийн тухай, Усан замын тээврийн тухай хууль зөрчих, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль зөрчих, Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль зөрчих, Хоршооны тухай хууль зөрчих, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль зөрчих, Ирээдүйн өв сангийн тухай хууль зөрчих, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль зөрчих, Өмгөөллийн тухай хууль зөрчих, Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль зөрчих зэрэг мөн 56 зүйлд хамаарах зөрчил 1-10 удаа бүртгэгдсэн байна.

Зөрчлийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд Чөлөөт бүсийн тухай хууль зөрчих Биеийн тамир, спортын тухай хууль зөрчих, Соёлын тухай хууль зөрчих, Аялал жуулчлалын тухай хууль зөрчих, Инновацийн тухай хууль зөрчих, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль зөрчих зэрэг 29 зүйлд хамаарах зөрчлүүд нэг ч бүртгэгдэж байгаагүй байна.

Дээрх нөхцөл байдал, тоо баримтад үндэслэн Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан бүлэг тус бүрд хамаарах салбарын хуульд заасан зөрчилд тооцох үйлдлүүдийг дахин нягталж, дараах байдлаар тусгалаа.

Шийтгэлийн шинэ төрөл болох сануулах шийтгэлийг тусгай ангийн нийт 88 зөрчлийн үйлдэлд хүнд, 21 зөрчлийн үйлдэлд хуулийн этгээдэд оногдуулахаар тусгалаа.

Зарим зөрчилд торгох шийтгэлийн хэмжээг дээд, доод хязгаартай байхаар тусгасан бөгөөд ийнхүү эрх бүхий этгээд хуулийн тусгай ангид заасан хэмжээнд нийцүүлэн уг шийтгэлийг оногдуулах зохицуулалтыг шинээр бий болголоо. Хуулийн төслийн тусгай ангид заасан нийт тусгай ангийн нийт 40 хэсэгт заасан зөрчилд оногдуулахаар заасан бөгөөд үүнээс 11 нь зөвхөн хүнд, 3 нь зөвхөн хуулийн этгээдэд, бусад нь хүн, хуулийн этгээдэд оногдуулах торгох шийтгэлийн хэмжээг дээд, доод хязгаар буюу интервалтай байна.

Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан зөрчлийн үйлдлүүд хоорондоо давхацсан, зарим тохиолдолд адил үйлдэлд өөр өөр заалтаар ялгаатай шийтгэлийн хэмжээ тусгагдсаныг залрууллаа.

Түүнчлэн эрх бүхий этгээдийн хуульд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг залруулах боломжтой гэж үзэж Зөрчлийн тухай хуулиар зөрчилд тооцох үйлдлээс хаслаа. Ингэхдээ нийгмийн хор аюул шууд учрах боломжгүй, үр дагаврыг хүн, хуулийн этгээд нь эрх бүхий этгээдийн шаардлагын дагуу арилгах боломжтой, иргэн, хуулийн этгээдэд учруулах дарамт, хүнд суртлыг багасгахад анхаарч боловсрууллаа.

Мөн Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан зөрчлийн үйлдлээс гадна эрх бүхий этгээдийн баталсан дүрэм, журмыг зөрчсөн зөрчил буюу хэт ерөнхий байсан үйлдлүүдийг тодорхой болголоо. Ингэхдээ эрх бүхий этгээдийн шийдвэр буюу Засгийн газрын тогтоол, сайдын тушаалаар баталсан холбогдох дүрэм, журмыг судалж, нийгмийн дэг журмын хангах шаардлага, хор аюул, үр дагаврын шинжийг харгалзан зарим тодорхой үйлдлүүдийг тусгалаа. Ийнхүү Зөрчлийн тухай хуульд дүрэм, журам, зааврыг зөрчсөн гэж хэт ерөнхий (задгай) байдлаар тусгагдсан 126 хэсэг, заалт байсныг 59 болгон бууруулж тусгалаа. Харин Цөмийн энергийн тухай хууль зөрчих, Хог хаягдлын тухай хууль зөрчих, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, жагсаал, цуглаан зохион байгуулах, галт зэвсэг эзэмших, ашиглах, соёлын өвийг хадгалах, хамгаалахтай холбоотой болон зарим аюулгүй ажиллагааны дүрэм, журмын зөрчлийг хэвээр үлдээсэн болно.

Түүнчлэн хуулийн төслийн тусгай ангид заасан зөрчлийн үйлдлийг шинэчлэн боловсруулахдаа хүрээлэн байгаа орчны эсрэг зөрчил буюу байгаль орчин бохирдуулах, доройтуулах, нөхөн сэргээх үүргээ биелүүлэхтэй холбоотой зөрчлүүдийг багасгах, шийтгэлийн хэмжээнд өөрчлөлт оруулахаас аль болох татгалзаж, харин зарим үйлдлийг шинээр зөрчилд тооцохоор тусгалаа.

Номын сангийн тухай хууль зөрчих, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль зөрчих, Энгийн харуул манааны журам зөрчих, Үрийн тариалангийн даатгалын тухай хууль зөрчих, Давс иоджуулах тухай хууль зөрчих, Хоршооны тухай хууль зөрчих, Нөхөрлөлийн тухай хууль зөрчих зөрчлийг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд хяналт тавих боломжтой гэж үзэж хассан болно.



Зөрчлийн үйлдлүүдэд ямар нэг урьдчилсан арга хэмжээ авах боломжгүйгээр Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл оногдуулж байгааг өөрчилж, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу эрх бүхий этгээд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар хууль, дэг журмыг сахиулах боломжийг бүрдүүлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, хууль тогтоомж, нийгмийн дэг журмыг хангуулахад хариуцлагын уян хатан механизмыг бий болгоход анхаарч боловсрууллаа.

Зөрчлийн үйлдлийг хасаж байгаа нь аливаа хуулийн хяналтаас гадуур байх ойлголт биш бөгөөд тухайн зөрчлийг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд шийдвэрлэх, түүнчлэн хэрэв төрийн эрх бүхий албан хаагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй бол Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйл буюу Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах зөрчилд тооцон шийтгэл хүлээлгэх зохицуулалт үйлчилнэ.

Мөн Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр баталсан Өргөн нэвтрүүлгийн тухай хууль зөрчих, 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр баталсан Хөдөлмөрийн тухай хууль зөрчих, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай, Нийтийн мэдээллийн тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль зөрчих, Кибер аюулгүй байдлын тухай хууль зөрчих зэрэг зөрчлийн үйлдлийг нарийвчлан тусгаад байна.

Түүнчлэн Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх шатанд байгаа дээрх хуулийн төслүүдтэй уялдуулах шаардлагаар нэмж тусгаад байна. Тухайлбал, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай зөрчлийн үйлдлийг шинээр тусгалаа.

Хуулийн төслийн тусгай ангид заасан 104 зөрчлийг Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжтэй уялдуулан тодорхойлов. Тухайлбал, гэмт хэрэгтэй давхардуулан хуульчилсан 23 зөрчил, хэрэглэхэд хүндрэлтэй, ойлгомжгүй байсан 81 зөрчлийн шинжийг нарийвчлан тодорхойлж, зөрчлийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан хөрөнгө завших, хулгайлах, бэлгийн дарамт учруулах, зөрчлийг гэмт хэрэгт тооцохоор тусгалаа.

Түүнчлэн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Зөрчлийн тухай хуульд баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчлийн тоо 10 байсан. Харин хуулийн шинэчилсэн найруулгын төслөөс хөрөнгө завших, хулгайлах зөрчлийг хасаж, Эрүүгийн хуульд тусгах болсонтой холбоотойгоор, гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюулын үед эрх бүхий байгууллагаас тогтоосон хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт, тэдгээрийн дэглэм зөрчсөн, эсхүл саад учруулсан зөрчил оногдуулах баривчлах шийтгэлийг хасаж боловсруулсантай холбогдуулан нийт 6 зөрчилд баривчлах шийтгэл хүлээлгэх зохицуулалттай байна. Эдгээр нь:

- бусдыг доромжилж, эсхүл хэрүүл маргаан үүсгэж, эсхүл өдөөн хатгаж, эсхүл олон нийтийг үл хүндэтгэж үйлчилгээний болон дарааллын журам зөрчсөн нь бусдын амгалан тайван байдал, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан;
- хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдээс бусад бодис, түүхий эдийг хэрэглэж мансуурсан;
- гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, бусадтай харилцахыг хязгаарласан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан;

- тэтгэлэг төлөгч шүүхийн шийдвэрээр сар бүр төлбөл зохих хүүхдийн тэтгэмжийг гурван сараас дээш хугацаанд төлөөгүй;
- жагсаал цуглааныг зохион байгуулагч, оролцогч зэвсэг, зэвсгийн чанартай зүйл, хорт бодис, тэсэрч дэлбэрэх бодис, амьтан авч явсан;
- тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн;
- Түүх, соёлын дурсгал зүйлийг санаатайгаар эвдсэн, гэмтээсэн, устгасан.

Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 16 бүлэг байхаар боловсруулсан нь зүйл, хэсэг, заалтын хувьд хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн зүйл, хэсэг, заалтын тоотой ойролцоо байна. Харин энэ нь хүчин төгөлдөр хуульд хуулиар хориглосон, журамд заасныг зөрчсөн, үүргээ биелүүлээгүй зэрэг хэт ерөнхий байдлаар нэг хэсэг, заалтад багтаан тусгасан боловч энэ нь салбарын хууль, захиргааны хэм хэмжээний актад заасан үйлдлүүд нь хэдэн ч зөрчил болж өсөх боломжтой байгаа тул хүрээ хязгаарын харьцангуй тодорхой болголоо.

Хуулийн төслийн тухайн бүлэгт харьяалах зүйлийг бүлгийн агуулгад хамаарах байдлаар оновчтой тусган дараах байдлаар боловсрууллаа.

**Тавдугаар бүлэгт нийтийн хэв журам, ёс суртахуун, өмчлөх эрх, олон нийтийн аюулгүй байдлын эсрэг зөрчлийг тусгалаа.**

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Зөрчлийн тухай хуульд тусгагдсан хулгайлах, хөрөнгө завших, алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө завших, бэлгийн дарамт учруулах зөрчлийг зөрчилд тооцох үйлдлээс хасаж, гэмт хэрэгт тооцохоор тусгаж үүнтэй холбогдуулан Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдан боловсрууллаа. Харин Бэлгийн дарамт учруулах зөрчлийн 2 дахь хэсэг буюу ажил олгогч хөдөлмөрийн дотоод журамд ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгах үүргээ биелүүлээгүй үйлдлийг Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн Хөдөлмөрийн тухай хууль зөрчих зөрчлийн хэсэгт тусгасан болно.

Танхайрах зөрчлийг “олон нийтийн газарт” , “орон байранд” гэж тусгайлан заасныг хасаж, хаана үйлдсэнээс хамаарахгүйгээр зөрчилд тооцохоор тусгалаа.

Гэр бүлийн хүчирхийллийн хууль зөрчих зөрчлөөс хүүхдийн бэртэл гэмтэл, өвчлөл, сэтгэл санааны байдал, хичээл таслалт, сургууль завсардалт зэрэг хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, зан үйлд гарч байгаа сөрөг нөлөөллийн шалтгааныг тогтоох, хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг шалгах үүргээ биелүүлээгүй үйлдэл нь гэр бүлийн хүчирхийллийн талаар хуулиар хүлээсэн мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй зөрчилд багтах агуулгатай тул хасаж тусгалаа.

Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, бусадтай харилцахыг хязгаарласан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан үйлдлүүдэд баривчлах шийтгэл оногдуулах зохицуулалт үйлчилж байна. Гэтэл хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд тус гэр бүлийн хүчирхийллийн зөрчил нийт бүртгэгдсэн зөрчлийн эхний 5 зөрчилд байнга бүртгэгдэж ирсэн бөгөөд ийнхүү гэр бүлийн хувьд нэгийг баривчлах шийтгэл ирсэн

нь энэ төрлийн шийтгэл оновчтой, үр дүнтэй биш гэдэг нь нотлогдож байна. Харин гэр бүлийн зөрчлийг анх удаа үйлдэж байгаа, эсхүл гэр бүлийн маргаанаас үүдэн гарсан зөрчилд юуны түрүүнд баривчлах шийтгэл оногдуулахгүйгээр уяан хатан зохицуулалтыг бий болгох, албан сургалтад хамруулах, нөлөөллийн арга хэмжээ авах, ажил хөдөлмөр эрхлэх боломж олгох нь үр дүнтэй байж болох тул харин гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон буюу биед нь халдсан үйлдэлд баривчлах шийтгэл оногдуулахаар өөрчлөн тусгалаа. Энэ талаар эрх бүхий байгууллагын судалгаа, дүгнэлт, гэр бүлийн асуудал эрхлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал ирүүлснийг үндэслэсэн болно.

Зарим зүйлд заасан “Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй” гэж ерөнхий байдлаар тусгасныг тодорхой болгосон. Тухайлбал, Гэр бүлийн хүчирхийллийн талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол гэж ерөнхий байдлаар тусгасныг холбогдох хуулиас зайлшгүй зөрчилд тооцох шаардлагатай үйлдлийг тусгалаа.

Орон сууцны оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах зөрчлийг зөвхөн нийтийн зориулалттай орон сууцанд үйлчлэх зохицуулалттай байсныг өөрчилж шөнийг цагаар орон сууц, гэр хороолол, зуслангийн байр хаана байгаагаас хамаарахгүйгээр оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулсныг зөрчилд тооцох зохицуулалт бий болголоо.

Түүнчлэн галт зэвсэг эзэмшүүлэх гэрээг хуульд заасан хугацаанд бүртгүүлээгүй галт зэвсэг, сумыг худалдан авагч иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг хуульд заасны дагуу цахим бүртгэлд хадгалаагүй бол гэсэн шууд үр дагавар үүсээгүй, хохирол учрахаас өмнө эрх бүхий этгээдийн хууль ёсны шаардлагын дагуу биелүүлэх боломжтой гэж үзсэн тул зөрчилд тооцохгүйгээр хасаж, харин хууль бусаар хил нэвтрүүлсэн үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй байх тул зөрчлөөс мөн хасаж тусгалаа.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль зөрчих зөрчилд иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хангах зорилгоор жагсаал, цуглаан зохион байгуулахтай холбоотой зөрчлийн зарим үйлдлүүдэд эхний удаа сануулах шийтгэлийг оногдуулахаар тусгаад байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлаас шинээр баталсан Хүний эрхийг хамгаалагчийн тухай анхдагч хуулийн зөрчлийн үйлдлийг нягталж, хүний эрх “хамгаалагчийн хүний эрх хамгаалах үйл ажиллагаа”-нд санаатайгаар саад учруулсан гэж тодорхой болгож тусгалаа.

Мөн энэ бүлэгт энгийн харуул манааны журам зөрчих, Ирээдүйн өв сангийн тухай хууль зөрчих зөрчлийг зөрчилд тооцох шаардлагагүй гэж үзэн хассан болно. Түүнчлэн энэ бүлэгт зарим төрлийн зөрчлийг шинээр тусгалаа. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль зөрчих зэрэг.

Мөн энэ бүлэгт Монгол Улсын хилийн тухай хууль зөрчих зөрчилд хилийн зурвас бүсэд нисгэгчгүй төхөөрөмж, агаарын хөлгөөр нислэг үйлдсэн, зохих зөвшөөрөлгүйгээр улсын хил нэвтэрсэн, хилийн боомтын хяналт шалгалтын бүсэд

улсын хил нэвтэрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөний чиглэл, байрлал өөрчлөх зэрэг зөрчлийг шинээр тусгалаа.

Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль зөрчих зөрчил нийт 6 үйлдлийг тооцож байсан. Эдгээрийн нийт 5 үйлдэл нь Зар сурталчилгааны тухай хууль зөрчих, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль зөрчих, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль зөрчих зөрчлүүдтэй давхацсан тул хасаж тусгалаа.

Галын аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчилд заасан урьдчилан сэргийлэхтэй холбоотой үйл ажиллагаануудыг зөрчсөн үйлдлийг багасгаж, эдгээр үйлдэл, эс үйлдэхүйг эрх бүхий этгээдийн даалгавар шаардлага, хяналт шалгалтын хүрээнд арилгуулах боломжтой гэж үзсэн болно.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль зөрчих зөрчилд хэрэгжүүлэгч байгууллагаас ирүүлсэн санал, практик шаардлагын үндэслэн гадаадын иргэн ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан зөрчлийг нэмж тусгасан.

Мөн энэ бүлэгт тусгагдсан Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль зөрчих, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль зөрчих зүйлүүдийг есдүгээр бүлэг хэрэглэгч, аж ахуйн үйл ажиллагааны журмын эсрэг зөрчил гэсэн бүлэгт шилжүүлэн тусгасан болно.

**Зургаадугаар бүлэгт хүн амын эрүүл мэнд, хүнс, эрүүл ахуйн журмын эсрэг зөрчлийг тусгалаа.**

Эрүүл мэндийн тухай хууль зөрчих зөрчилд зарим журам зөрчсөн үйлдлийг тодорхой болгосон Тухайлбал, жирэмслэлтийг эмнэлгийн аргаар таслан зогсоох журам зөрчсөн гэснийг Эрүүл мэндийн сайдын баталсан журмаас тусгайлан тодорхой үйлдлийг зөрчилд тооцохоор тусгалаа. Өөрөөр хэлбэл, журамд заасан бүх үйлдлийг зөрчилд тооцон шийтгэл хүлээлгэх ерөнхий зохицуулалт үйлчилж байсныг зөрчлийн үйлдлийг тодорхой болгосон.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль зөрчих зөрчлийн 2 хэсэг нь хоорондоо агуулгын хувьд давхардсаныг нэгтгэн, мөн субъектийг илүү тодорхой болгож “эмнэлгийн мэргэжилтэн” гэж нэмж тусгалаа. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийг сурталчилсан үйлдлийг тусгайлан заалт болгон нэмж тусгалаа.

Хог хаягдлын тухай хууль зөрчих зөрчлийн үйлдлээс аюултай хог хаягдалтай холбоотой бүртгэх, тайлагнахаас бусад үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор тусгаж, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар боловсруулсан болно.

Органик хүнсний тухай хууль зөрчих, Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль зөрчих зөрчлийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэж тусгасныг хуулиас шаардлагатай тодорхой үүргүүдийг сонгон авч, зөрчлийн үйлдлийг тодорхой болголоо.

Тамхины хяналтын тухай хууль зөрчих зөрчлийн үйлдэлд утаат тамхинаас гадна манай улсын улсад шинээр зохицуулалт шаардлагатай байгаа электрон тамхины худалдаа, хэрэглээтэй холбоотой зөрчлийг шинээр тусгалаа.

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтэй тэмцэх тухай хуулийн зөрчил нь манай улсын хувьд гэмт хэрэг зөрчил үйлдэгдэх томоохон шалтгааны нэг болдгийн хувьд энэ төрлийн зөрчлийн үйлдэлд хүлээлгэх хариуцлагыг харьцангуй чангаруулж тусгалаа.

Түүнчлэн энэ бүлэгт байсан Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль зөрчих, Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийх, Олон улсын хөл хориот өвчний талаар мэдүүлэхээс татгалзах зэрэг зөрчлийг Нийтийн хэв журам, ёс суртахуун, өмчлөх эрх, олон нийтийн аюулгүй байдлын эсрэг зөрчлийн бүлэгт шилжүүлэн тусгасан болно.

**Долоодугаар бүлэгт нийтийн зориулалттай өмч, хүрээлэн байгаа орчны эсрэг зөрчлийг тусгалаа.**

Газрын тухай хуулийн зөрчих зөрчилд заасан зарим үйлдэл нь иргэний эрх зүйн харилцааны асуудал, түүнчлэн бүртгэлийн байгууллагад нэгэнт бүртгээгүй бол газартай холбоотой аливаа эрх үүсэхгүй тул бүртгэлтэй холбоотой зөрчлийн үйлдлийг хасаж тусгасан болно. Түүнчлэн бэлчээрийг зохистой ашиглах хамгаалах журмыг тодорхой болгон тусгалаа.

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль зөрчих зөрчлийг ерөнхий байдлаар тусгасныг зөрчлийн үйлдлийг тодорхой болгож тусгалаа. Байгаль орчин, газрын хөрсийг хамгаалах, нийгмийн дэг журам хангуулах зорилгоор тусгайлан зөвшөөрснөөс бусад газарт автомашин, мотоспортын үйл ажиллагаа, уралдаан, тэмцээн зохион байгуулах явцад эвдэрсэн газрын хөрсийг нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй бол шийтгэл хүлээлгэх зохицуулалтыг шинээр тусгалаа.

Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлээр хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийг хохирлын хэмжээ шаардахгүй хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байхаар заасан. Ойн нөөц бүхий газрын оршин суугчид хууль бусаар түлшний мод бэлтгэсэн тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэн шүүхэд шилжүүлэх тохиолдолд нэмэгдэж байгаа талаар эрх бүхий байгууллагаас мэдээлэл ирүүлж байна. Иймд практик шаардлагыг үндэслэн хууль бусаар ойгоос мод бэлтгэсэн үйлдлийг Ойн тухай хууль зөрчих зөрчлийн зүйлд нэмж тусгалаа.

Агаарын тухай хууль зөрчих зөрчлийн агаарын чанарын мэдээг тогтоосон хугацаанд мэдээлээгүй үйлдлийг хасаж, агаар бохирдуулах бодисын хаягдлын стандартаас хэтэрсэн бохирдуулах бодис гаргадаг, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг тээврийн хэрэгсэл, эсхүл хөдөлгөөнт бусад эх үүсвэр ашиглан агаар бохирдуулсан үйлдлийг хуулийн төслийн 6.1 буюу Агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх зүйлийн Хот, суурин газарт стандартад нийцсэн утааны шүүлтүүргүй дизель хөдөлгүүртэй авто тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулсан үйлдэлтэй давхацсан тул мөн хассан болно. Мөн “журам зөрчсөн” гэх зарим үйлдлийг тодорхой болголоо.

Ургамлын тухай хууль зөрчих зүйлд харь ургамлыг зөвшөөрөлгүйгээр байгалд тарималжуулсан бол учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зохицуулалт бий болгохоор тусгалаа.

Ургамал хамгааллын тухай хууль зөрчих зөрчилд ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамалтай тэмцэх технологи зөрчсөн үйлдлийг хассан. Энэ заалт нь хэт ерөнхий, Ургамал хамгаалах тухай хуулиар үүрэг болгосон,

хориглосон зохицуулалт байхгүй байна. Иймд технологи зөрчсөн асуудлыг холбогдох эрх бүхий этгээдийн хяналт шалгалтаар шийдвэрлэх боломжтой гэж үзлээ.

Ашигт малтмалын тухай хууль зөрчих зөрчлийн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх нийтлэг үүргээ биелүүлээгүй гэснийг тодорхой болгож тусгасан. Газрын тосны тухай хууль зөрчих үйлдлийн хайгуул олборлолтын ажиллагаа явуулахыг хориглосон хязгаарласан газар үйл ажиллагаа явуулсан үйлдлийг Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгтэй давхацсан гэж үзэн хассан болно. Эрүүгийн хуулийн 20.11, 24.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргээс ялгах зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмшигч хайгуул, ашиглалтын журам мөрдөөгүйгээс хүн амын эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд хохирол учруулсан үйлдлийг шинээр тусгав.

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль зөрчих үйлдлийн “хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй” хуулиас тодорхой үүргүүдийг биелүүлээгүй тодорхой үйлдлийг тусгасан.

Ашигт малтмалын тухай хууль зөрчих, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль зөрчих зөрчлийн үйлдлүүдийн хүрээлэн байгаа орчинд учруулах нөлөөлөл, эдийн засаг, нийгмийн үр дагаварыг харгалзан зөрчлийн үйлдлийг харьцангуй хэвээр хадгалсан болно.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих зөрчлөөс байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг тогтоосон хугацаанд, холбогдох газарт тайлагнаагүй үйлдлийг зөрчилд тооцох үйлдлээс хассан болно.

Усны тухай хууль зөрчих зөрчилд ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлага гэж ерөнхий тусгасныг хуульд заасныг үндэслэн зөрчлийн үйлдлийг тодорхой болгосон.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль зөрчих зөрчилд заасан зарим үйлдэл нь Геодезийн тухай хууль зөрчих зөрчилтэй давхацсан, мөн иргэн нь төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрийг биелүүлээгүй, хуульд заасан үүргээ биелүүлээгүй гэх ерөнхий тусгасныг хассан. Бусад зохицуулалтын агуулга болон зөрчлийн үйлдлийг хэвээр хадгалж найруулгыг сайжруулсан.

### **Наймдугаар бүлэгт боловсрол, соёл, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны журмын эсрэг зөрчилд**

Боловсролын тухай хууль нь боловсролын боловсролын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, иргэний сурч боловсрох эрхийг хангахтай холбогдсон нийтлэг харилцааг зохицуулдаг. Иймд Зөрчлийн тухай хуулийн Бага дунд боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Мэргэжлийн боловсролын тухай хууль зөрчих зөрчлийн “тусгай зөвшөөрөлд заасан орчин, шаардлага хангаагүй”, “тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулах” зэрэг үйлдлүүд нь Боловсролын тухай хууль зөрчих зөрчилтэй давхардсан байх тул хассан болно.

Харин дээд боловсролын тухай хууль зөрчих хууль тогтоомжид заасан багц цаг, эсхүл сургалтын хөтөлбөрийн агуулгыг бүрэн хангаагүй хүнийг элсүүлсэн, төгсгөсөн үйлдлийг шинээр тусгалаа.

Мөн Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих зөрчлийн үйлдлүүдийг зарчмын хувьд хэвээр хадгалж, соёлын өвийн хадгалах, хамгаалах Засгийн газрын бодлогын хүрээнд энэ төрлийн зөрчлийг хариуцлагыг чангатгаж, торгох шийтгэлийн хэмжээг нэмэгдүүлэн тусгасан болно.

Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд заасан зарим ерөнхий байдлаар тусгасан зөрчлүүдийг хуулийг үндэслэн үйлдлүүдийг тодорхой болгон тусгалаа.

Монгол Улсын Их Хурлаас 2021 онд баталсан Кино урлагийг дэмжих тухай, Музейн тухай хууль зөрчих зөрчил, түүнд оногдуулах шийтгэлийн хэмжээг Зөрчлийн тухай хуулийн ерөнхий ангид заасан зохицуулалтыг баримтлаагүй тусгаж баталсныг засаж боловсрууллаа.

**Есдүгээр бүлэгт хэрэглэгч, аж ахуйн үйл ажиллагааны журмын эсрэг зөрчлийг тусгалаа.**

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль зөрчих зөрчлийн үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгч бараа, ажил, үйлчилгээний доголдлыг арилгах хугацаа тогтоох, бараанд засвар хийх, техникийн үйлчилгээ үзүүлэх, чанарын доголдлыг арилгах үүргээ биелүүлээгүй, үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн үүргээ хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлийг төрийн хяналт шалгалтаар шийдвэрлэх боломжтой гэж үзэн хасаж, бусад зөрчлийг хэвээр хадгаллаа.

Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих зөрчилд оногдуулах шийтгэлийн хэмжээг дээд доод хязгаартай байхаар тусгалаа. Өөрөөр хэлбэл энэ төрлийн зөрчил үйлдсэн хүнийг 20 нэгжээс 40 нэгжээр, хуулийн этгээдийг 200 нэгжээс 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулах зохицуулалтыг тусгалаа. Нийтлэг гардаг тус зөрчлийн үйлдэлд сануулах шийтгэлийг хэрэглэхээр тусгалаа.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний тухай хууль зөрчих зөрчилд жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих сангаас олгосон хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан бол зээлийн хөрөнгийг эргүүлэн төлүүлж, торгох шийтгэл оногдуулахаар тусгалаа.

Өрсөлдөөний тухай хууль зөрчих зөрчлийн үйлдлийг хэвээр хадгалсан. Харин тус зүйлийн тайлбар хэсэгт тусгасан шийтгэлийг хөнгөрүүлж болох тухай хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн зохицуулалтуудыг хэвээр хадгалж тусгалаа.

**Аравдугаар бүлэгт үнэт цаас, банк, санхүү, гааль, татвар, мэргэжлийн хяналт, даатгалын журмын эсрэг зөрчлийг тусгалаа.**

Хорооны зохицуулалттай этгээдийн хууль тогтоомжийг мөрдөж ажиллах хариуцлага, зохицуулалттай этгээд зөрчлийг дахин давтан гаргахаас урьдилан сэргийлэх, ФАТФ-аас өгсөн зөвлөмж бүхий санхүүгийн байгууллагын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашиг, сонирхлыг хамгаалах, тэдгээрийн эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх, түүнчлэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх чиглэлд онцгой ач холбогдол өгч одоогийн хүчин төгөлдөр дагаж мөрдөж буй Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлүүдийг өөрчлөхгүй байх нь зүйтэй байна.

Иймд Банкны тухай хууль зөрчих, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж, Хадгаламж зээлийн хоршооны тухай хууль зөрчих, Үнэт цаасны тухай хууль зөрчих, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль зөрчих, Даатгалын тухай хууль зөрчих, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль зөрчих үйлдэл, Жолоочийн даатгалын тухай хууль зөрчих, Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль зөрчих, Хөгжлийн банкны тухай хууль зөрчих, Онцгой албан татварын тухай хууль зөрчих, Валютын зохицуулалтын тухай хууль зөрчих, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчлийг хүчин төгөлдөр хуулийн зохицуулалтыг хэвээр үлдээсэн болно.

Харин энэ бүлэгт тусгагдсан Аудитын тухай хууль зөрчих зөрчлүүдийн давхардсан заалтуудыг нэгтгэсэн, мөн “хуулиар хүлээсэн үүрэг” ийг тодорхой болголоо. Харин хуульд заасан үүрэг тус бүрийг зөрчилд тооцож байсныг өөрчилж, ёс зүйн шинжтэй, зарим зарчим баримтлаагүй үйлдлийг зөрчилд тооцож байсныг хасаж, мөн зарим үйлдлийг тусгай зөвшөөрөл олгох этгээдийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх боломжтой гэж үзэн хаслаа.

Төрийн хяналт шалгалтын тухай хууль зөрчих үйлдлийн 2 дахь хэсэг болох төрийн хяналт шалгалтад хамрагдах үүрэг бүхий этгээд холбогдох баримт бичгийг гаргаж өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзсан, засварласан, гэмтээсэн, зайлсхийсэн утгасан, хуурамч баримт бичиг гаргаж өгсөн үйлдлийг хуулийн төслийн 15.2 дугаар зүйлийн төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах зүйлд тусгагдсан зөрчилтэй давхардсан тул хассан болно.

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хууль зөрчих зөрчлөөс амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлох, экспортлох, дамжуулан өнгөрүүлэх, тээвэрлэх хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй зөрчил нь энэ зүйлийн бусад заалтуудыг тодорхой тусгагдсан байх тул давхардлыг арилгаж боловсрууллаа.

**Арван нэгдүгээр бүлэгт барилга, үйлдвэрлэл, эрчим хүчний журмын эсрэг зөрчлийг тусгалаа.**

Энэ бүлэгт Барилгын тухай хууль зөрчих үйлдлүүдийн зарим зөрчлийг зөрчилд тооцох үйлдлээс хассан. Тухайлбал, барилга байгууламжийн норм нормативын баримт бичгийн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүй хэвлэсэн, зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээд барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлээгүй зэрэг үйлдлийг хасаж, эрх бүхий этгээдийн хяналт шалгалтын хүрээнд хууль дүрмийг сахиулан ажиллах боломжтой гэж үзлээ.

Геодезийн тухай хууль зөрчих зөрчилд заасан зарим давхардлыг арилгаж, зөрчилд тооцох үйлдлээс зарим үйлдлийг хаслаа. Тухайлбал, мэдээ мэдээллийг эрх бүхий байгууллагад үнэ төлбөргүй шилжүүлээгүй, байнгын цэг тэмдэгтийн тухайн нутаг дэвсгэрийн Засаг даргад хүлээлгэн өгөөгүй зэрэг үйлдлийг хасаж, төрийн хяналт шалгалтын хүрээнд шийдвэрлэх боломжийг бий болголоо. Мөн геодезийн багажид баталгаажилт хийлгээгүй үйлдэл нь хуулийн төслийн Хэмжил зүйн тухай хууль зөрчих зөрчлийн үйлдэлтэй давхардсан тул хассан.



Хот суурин газрын дахин хөгжүүлэх тухай хууль зөрчих зөрчилд тус хууль байхгүй зохицуулалтыг зөрчилд тооцсоныг хасаж, харин хуулиар хориглосон тодорхой 2 үйлдлийг тусгалаа.

Хаягжуулалтын тухай хууль зөрчих зөрчлийг тодорхой болгож, Засгийн газрын тогтоолоор баталсан Хаягжуулалтын журамд заасан үйлдлээс хориглосон тодорхой зохицуулалтыг сонгон авч тусгалаа.

Цөмийн энергийн тухай хууль зөрчих зөрчлийг үйлдлүүдийг нийгмийн хор аюулын хэр хэмжээг харгалзан зарчмын хувьд хэвээр хадгалсан бөгөөд харин мэдээлэх, тайлагнах зэрэг урьдчилан сэргийлэхтэй холбоотой зарим үйлдлийг хасаж, төрийн хяналтын шалгалтын хүрээнд шийдвэрлэх боломжтой гэж үзсэн болно.

**Арван хоёрдугаар бүлэгт хөдөө аж ахуй, газар тариалангийн талаар тогтоосон журмын эсрэг зөрчлийг тусгалаа.**

Тариалангийн тухай хууль зөрчих зөрчлийн тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч тариалангийн газрыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн 2 жил өнжөөхдөө сум, дүүргийн Засаг даргад албан ёсоор мэдэгдээгүй, агрохими, агрофизикийн шинжилгээний явцад зөрчил илэрснийг итгэмжлэгдсэн лаборатори сумын газрын даамал, тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн, дүүргийн газрын албанд мэдэгдээгүй, агрохими, агрофизикийн шинжилгээг таван жил тутам тариалангийн газрын эзэмшигч, ашиглагч өөрийн хөрөнгөөр хийлгээгүй зэрэг зөрчлийг зөрчилд тооцох үйлдлээс хасаж боловсрууллаа.

Малын генетик нөөцийн тухай хууль зөрчих үйлдлийн малчин, мал бүхий этгээд, хуулийн этгээд нь цөм сүргийн болон үржлийн малыг технологи хугацаанд үзлэг ангил алтад хамруулаагүй, ашиг шимт чанарыг үнэлүүлж, баталгаажуулаагүй, үр, хөврөлийг мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжийн хяналтын доор ашиглаагүй, эрх бүхий мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөр үүлдрийн мал, эсхүл стандартын шаардлагад тэнцэхгүй хээлтүүлэгчийг сайжруулагчаар ашигласан, малыг дахин давтагдахгүй хувийн дугаараар ялган тэмдэглүүлэх, нэгдсэн бүртгэлд хамруулах үүргээ биелүүлээгүй зэрэг үйлдлийг зөрчилд тооцох шаардлагагүй гэж үзэж хаслаа.

Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль зөрчих үйлдлийн малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нь дархлаажуулалт хийх, сорьц авах үед болон мал, амьтанд халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн, тодорхой бус шалтгаанаар хорогдсон тохиолдолд авч хэрэгжүүлэхээр хуульд заасан үүргээ биелүүлээгүй зөрчлийг хассан.

**Арван гуравдугаар бүлэгт мэдээлэл, харилцаа холбооны журмын эсрэг зөрчлийг тусгалаа.**

Энэ бүлэгт заасан зөрчлийн үйлдлүүдийг харьцангуй хэвээр хадгалсан бөгөөд харин Улсын Их Хурлаас 2019 онд баталсан Өргөн нэвтрүүлгийн тухай хууль зөрчих үйлдлийг нэмж тусгасан болно.

**Арван дөрөвдүгээр бүлэгт тээвэр, тээврийн хэрэгслийн ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг зөрчлийг тусгалаа.**

Энэ зүйлд заасан зөрчилд эрх бүхий байгууллагад бүртгэгдсэн нийт зөрчлийн 95-аас дээш хувийг эзэлж байх бөгөөд зөрчлүүдийг хэвээр хадгалж, харин тус зөрчлийн үйлдлүүдэд сануулах шийтгэл хэрэглэх, торгох шийтгэлийн хэмжээг дээд доод хязгаартай байхаар тусгайлан анхаарч боловсрууллаа.

Энэ зүйлд нийт 58 зөрчлийн үйлдэлд шийтгэл оногдуулахаар тусгаснаас 36 хэсэгт заасан зөрчлийн үйлдэлд сануулах, 9 хэсэгт заасан үйлдэлд оногдуулах торгох шийтгэлийн хэмжээ нь дээд, доод хязгаартай байхаар тусгалаа. Өөрөөр хэлбэл, жолооч бүсээ зүүгээгүй байх, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй, эсхүл ядарсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, жолооч хот, суурин газраас бусад газар Замын хөдөлгөөний дүрэмд заасан баримт бичиггүй тээврийн хэрэгсэл жолоодсон, улсын бүртгэлийн дугаар нь арилсан, эсхүл бүдгэрч үзэгдэх байдал нь муудсан, эсхүл танигдахгүй бохирдсон, эсхүл дугаарыг буруу байрлуулсан тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон, Замын хөдөлгөөний дүрэмд заасан тээврийн хэрэгслийн дуут дохио өгөх журам зөрчсөн зэрэг үйлдэлд шууд торгох шийтгэл оногдуулж байгааг практик шаардлагад үндэслэн эхний удаа торгохгүйгээр, тухайн зөрчлийн хууль зүйн учир холбогдлыг тайлбарлаж сануулах шийтгэл оногдуулахаар тусгаад байна.

Түүнчлэн энэ зүйлийн 31-д заасан зөрчилд жолоочийн замын хөдөлгөөний дүрэмд заасан тээврийн хэрэгслийн хурд хэтрүүлэх зөвшөөрөгдсөн дээд хязгаар 30-50 хүртэл хувь байсныг 10-50 хүртэл хувь гэж өөрчлөн тусгалаа.

Ийнхүү сануулах шийтгэл оногдуулах болон энэ зүйлд заасан зөрчлийн үйлдэлд оногдуулах торгох шийтгэлийг тогтоосон хугацаанд биелүүлвэл 2 дахин хөнгөрүүлэх зохицуулалтад бүрэн хамрагдах бөгөөд эдгээр дэвшилтэт зохицуулалтууд нь иргэдийн амьдралд эерэг нөлөө үзүүлэх, торгох шийтгэлийн биелэлт нэмэгдэх, нийгмийн дэг журам хангагдах, хууль хэрэгжих баталгаа болох чухал ач холбогдолтой.

### **Арван тавдугаар бүлэгт төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааны эсрэг зөрчлийг тусгалаа.**

Энэ бүлэгт заасан зөрчилд тооцох үйлдлүүдийг зарчмын хувьд хэвээр хадгалсан бөгөөд зарим тодорхойгүй, ерөнхий заалтуудыг тодорхой болгон тусгалаа. Тухайлбал, Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль зөрчих, Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль зөрчилд заасан “хуулиар хориглосон үйл ажиллагаа” гэснийг хуулиас зарим тодорхой үйлдлийг зөрчилд тооцсон. Харин Хүн ам, орон сууцны тооллогын тухай хууль зөрчих үйлдэл нь төслийн 9.27 дугаар зүйл буюу Тайлан, мэдээ, тооллого, судалгаа, бүртгэлийн журам зөрчих зөрчилтэй давхардсан гэж үзэн хассан болно. Мөн Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль зөрчих үйлдэл практик шаардлагад үндэслэн тодорхой зөрчлүүдийг нэмж тусгасан болно.

Түүнчлэн Зөрчлийн тухай хуулиас тодорхой зөрчлүүдийг зөрчилд тооцохоос татгалзан, өөрөөр хэлбэл, төрийн хяналт шалгалтын хүрээнд хууль дүрмийг сахиулах боломжтой гэж үзэн хуулийн төслийг боловсруулсантай холбогдуулан энэ зүйлийн 15.2 буюу төрийн албан хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцэх үйлдэлд хүлээлгэх торгох шийтгэлийн хэмжээг нэмэгдүүлж тусгалаа.

### **Арван зургадугаар бүлэгт улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг зөрчил**

Энэ бүлэгт буюу Сонгуулийн тухай хууль зөрчих зөрчлийн үйлдэл, шийтгэлийн төрөл, хэмжээг зарчмын хувьд хэвээр хадгалсан болно.

### **Хуулийн төслийн дагалдуулан боловсруулсан хуулиудын талаар**

Зөрчлийн тухай хуульд тусгагдсан Хулгайлах, Хөрөнгө завших, Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө завших, Бэлгийн дарамт учруулах зөрчлийг зөрчилд тооцох үйлдлээс хасаж, гэмт хэрэгт тооцохоор тусгаад байна. Үүнтэй холбоотойгоор Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн хорих ял болон зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээ 3 сар байсныг 1 сар байхаар өөрчлөн тусгаад байна.

Бэлгийн дарамт учруулах зөрчил өнгөрсөн хугацаанд 8 удаа бүртгэгдсэн, мөн хүний эрхийн комисст Жендерийн тэгш байдлын тухай хуулийн дагуу 8 гомдол ирүүлсэн тоо баримт байна. Энэ нь ихэнхдээ нууц далд аргаар үйлдэгддэг, ажлын байранд, удирдах албан тушаалтан, дарга, багш сурган хүмүүжүүлэгчид байдаг гэсэн тодорхой судалгаа байгаа талаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлыг талаарх хэрэгжилтийн 18 дахь илтгэлд дурдсан байдаг<sup>3</sup>.

Түүнчлэн Улсын Их Хурлаас 2021 онд Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан бэлгийн дарамт, ялангуяа ажлын байран дахь бэлгийн дарамт, ажил олгогч, удирдах албан тушаалтан, багш сурган хүмүүжүүлэгчийн зүгээс учруулах бэлгийн дарамт учруулах, мөн хүсэл зоригийн эсрэг албадан хөдөлмөрлүүлэх, мөн хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх зэрэг үйлдлийг гэмт хэрэгт тус тус тооцохоор Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаад байна.

Зөрчлийн тухай хуулийн ерөнхий ангид зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол төрөөс үзүүлэх зарим үйлчилгээг хязгаарлах үндэслэл болохоор тусгасантай холбоотойгоор Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Төрийн байгууллагын үйл ажиллагааг шуурхай, чирэгдэлгүй болгох, нөгөө талаар эвлэлдэн нэгдэх, хангах эрхийг зорилгоор Засаг дарга жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор түүнийг бүртгэсэн эсэхээ бичгээр мэдэгдэх зохицуулалт үйлчил байгааг өөрчилж ажлын 1 өдрийн дотор хариу мэдэгддэг байхаар тусган Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсрууллаа.

Түүнчлэн зарим хуулийн нэр томъёог шинээр батлагдсан хуульд нийцүүлэх зорилгоор Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Номын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах

<sup>3</sup> <https://nhrcm.gov.mn/>

тухай, Музейн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл зэрэг хууль тогтоомжийн төслүүдийг тус тус боловсрууллаа.

---o0o---